

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

Монгол улс, Хөвсгөл аймаг, Тариалан сум, Мандал баг
Хөвсгөл Алтандуулга ХК, Утас: 70386030, Факс: 70386031

Огноо 2025.03.13

№ 03

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал
зарлан хуралдуулах тухай

Компанийн тухай хуулийн 59.4, 60.1, 60.2, 60.3, 76.1.2 дахь заалтыг үндэслэн
Төлөөлөн Удирдах Зөвлөлийн Хурлаас ТОГТООХ нь:

1. “Хөвсгөл алтан дуулга” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2025 оны
04 дүгээр сарын 25-ны өдрийн 11.00 цагт Хөвсгөл аймаг, Тариалан сум, Мандал багт
байрлах “Хөвсгөл алтан дуулга” ХК-ийн байранд хуралдуулсугай.

2. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар дараах асуудлуудыг хэлэлцүүлсүгэй.

- Компанийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан, 2025 оны
төсөв, төлөвлөгөө, зорилтын талаар танилцуулга
\\Танилцуулах нь: Г.Бат-Эрдэнэ - Компанийн Гүйцэтгэх захирал\\
- Компанийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд ТУЗ-ийн
гаргасан дүгнэлтийг батлах тухай
\\Танилцуулах нь: Д.Энхтогтох-ТУЗ-ийн гишүүн, Аудитын
хорооны дарга\\
- Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны зардлын төсвийг батлах тухай
\\Танилцуулах нь: Д.Батхуяг- ТУЗ-ийн дарга\\
- Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн цалин, урамшууллыг тогтоох
тухай
\\Танилцуулах нь: Д.Батхуяг- ТУЗ-ийн дарга\\
- “Ногдол ашиг хуваарилахгүй байх тухай” ТУЗ-ийн 2025 оны 02 дугаар
сарын 18-ны өдрийн 01 дүгээр тогтоолын талаар
\\Танилцуулах нь: Д.Батхуяг- ТУЗ-ийн дарга\\

3. Тус компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох эрх бүхий хувьцаа
эзэмшигчдийн танилцах бичиг баримтын жагсаалт, хэлэлцэх асуудлаар санал өгөх
“Саналын хуудас”-ны агуулгыг 1, 2 дугаар хавсралтаар баталсугай.

4. Компанийн тухай хуулийн 64.2-т заасны дагуу Хувьцаа эзэмшигчдийн хуралд
оролцох хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2025 оны 04
дүгээр сарын 03-ны өдрөөр тогтоосугай.

5. Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг хуралдуулах шийдвэр гарсантай холбогдуулан хурлын зарыг 2025 оны 03 дугаар сарын 17-ны өдрийн дотор Монголын хөрөнгийн биржийн цахим хуудас, өөрийн компанийн цахим хуудсаар, 2025 оны 03 дугаар сарын 24-нй өдөр болон 04 дүгээр сарын 9-ний өдөр “Өдрийн сонин”, “Өнөөдөр” сониноор дамжуулан хувьцаа эзэмшигчдэд мэдээлсүгэй.

6. Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцүүлэх баримт бичгийг бэлэн болгох эцсийн хугацааг 2025 оны 03 дугаар сарын 20-ны өдрөөр тогтоосугай.

7. Хувьцаа эзэмшигч нь энэхүү тогтоолын 1 дүгээр хавсралтад заасан бичиг баримтыг ажлын өдрүүдэд 10.00-17.00 цагийн хооронд Улаанбаатар хот, 8 дугаар хороо, 11 дүгээр хороолол, Ж.Батмөнхийн гудамж 39-2, “Велокс” оффисын 8 давхарт болон Хөвсгөл аймгийн Тариалан суманд байрлах компанийн байранд ирж танилцаж болохыг дурьдсугай.

8. Хувьцаа эзэмшигчдийн урьдчилж өгөх саналын хуудсыг хүлээн авах сүүлчийн өдрийг 2025 оны 04 дүгээр сарын 23-ны өдрийн 11:00 цаг байхаар тогтсугай.

9. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын даргаар Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга Д.Батхуягийг, хурал зохион байгуулах комиссын даргаар Компанийн гүйцэтгэх захирал Г.Бат-Эрдэнийг томилсугай.

10. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын даргаар “Хөвсгөл алтан дуулга” ХК-ийн тооцооны нягтлан бодогч Б.Юмжирдулам, гишүүдээр мөн компанийн хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, чанарын асуудал хариуцсан мэргэжилтэн Д.Анужин, “Алтан хажир” ХХК-ийн нягтлан бодогч Б.Сарангарав нарыг тус тус томилсугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ДАРГА Д.БАТХУЯГ

